



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 720

Улаанбаатар хот

### Үндсэн хоронго акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээх зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4, 6.5, 6.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Дээд шүүхийн Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, засаж сэлбэн ашиглах боломжгүй болсон 42 нэрийн, нийт 106,324,902.84 (нэг зуун зургаан сая гурван зуун хорин дөрвөн мянга есөн зуун хоёр төгрөг наян дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Монгол Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэрт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Акталж данснаас хасах хөрөнгөөс төмрийн хаягдлыг ялган тоолж “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” төрийн өмчит хувьцаат компанийн Улаанбаатар дахь салбарт тушаах;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

 Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2022 оны 12 дугаар сарын 21 өдрийн  
2022 дугаар тогтоолын хавсралт



УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС  
ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№		Хөрөнгийн Нэр төрөл	Ашиглалтад орсон огноо	Ашиглах жил	Нэгжийн үнэ	Тоо	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл
<b>МАШИН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ</b>							
1	1	принтер HP-2035	7/1/2013	4	800,000.00	1	800,000.00
2	2	принтер HP-P2035n	5/27/2013	4	342,110.00	8	2,736,880.00
3	3	принтер HP-P2055D	5/27/2013	4	502,080.00	10	5,020,800.00
4	4	сүлжээний тэжээлтэй свич	6/19/2013	4	392,250.00	2	784,500.00
5	5	сервер	12/26/2011	5	4,000,000.00	1	4,000,000.00
6	6	тог баригч	3/20/2017	5	137,750.00	9	1,239,750.00
7	7	Компьютер	1/1/2005	5	206,255.14	1	206,255.14
8	8	Компьютер	1/1/2005	5	1,417,578.70	1	1,417,578.70
9	9	Компьютер	1/1/2004	5	2,139,292.00	1	2,139,292.00
10	10	Компьютер 9020	4/16/2015	5	2,155,000.00	10	21,550,000.00
11	11	Компьютер 7020	12/24/2015	4	2,157,100.00	6	12,942,600.00
12	12	Компьютер 9020	12/24/2015	7	2,328,100.00	7	16,296,700.00
13	13	Компьютер 9020	12/24/2015	4	2,378,100.00	1	2,378,100.00
14	14	принтер	12/28/2015	4	351,170.00	5	1,755,850.00
15	15	принтер /HP laserJet ProM125A/	3/20/2017	4	514,050.00	6	3,084,300.00
16	16	принтер HP-1132	12/30/2014	4	332,550.00	2	665,100.00
17	17	принтер HP-2035	7/1/2013	4	509,000.00	1	509,000.00
18	18	ipad air	12/22/2017	4	3,400,000.00	1	3,400,000.00
<b>Дүн</b>						<b>73</b>	<b>80,926,705.84</b>
<b>ТАВИЛГА ЭД ХОГШИЛ</b>							
19	1	Сандал /төмөр холбоотой/	1/1/2004	10	80,800.00	10	808,000.00
20	2	Сандал	1/1/2004	10	138,800.00	2	277,600.00
21	3	Сандал	12/24/2007	10	142,905.00	1	142,905.00
22	4	Сандал	5/16/2007	10	143,000.00	2	286,000.00
23	5	Сандал	1/1/2000	10	159,000.00	1	159,000.00
24	6	Сандал	1/1/2000	10	188,544.00	19	3,582,336.00
25	7	Сандал/дарга	12/20/2016	5	157,599.00	1	157,599.00
26	8	Сандал/дарга	11/16/2011	10	319,900.00	1	319,900.00
27	9	Сандал/төмөр хөлтэй хар	4/29/2011	10	159,900.00	5	799,500.00
28	10	Сандал/уулзалтын	11/16/2011	10	175,900.00	7	1,231,300.00
29	11	Сандал/уулзалтын	2/16/2007	10	367,000.00	5	1,835,000.00
30	12	Сандал/хүлээлгийн	10/11/2011	10	220,000.00	2	440,000.00
31	13	Сандал/хүлээлгийн	11/18/2011	10	350,000.00	2	700,000.00
32	14	Тавиурууд	1/1/1997	10	176,712.00	1	176,712.00
33	15	Тумбочка	1/1/2006	10	86,000.00	2	172,000.00
34	16	Тумбочка	1/1/2004	10	104,990.00	3	314,970.00
35	17	Тумбочка	1/1/2004	10	133,990.00	1	133,990.00
36	18	Туслах ширээний холбоос	1/1/2004	10	90,980.00	1	90,980.00
37	19	Проекторын дэлгэц	12/22/2011	10	1,361,500.00	1	1,361,500.00
38	20	Прожекторын тавиур	1/1/2006	10	370,900.00	1	370,900.00
39	21	Эвхдэг прожекторын самбар	12/22/2011	10	2,900,000.00	1	2,900,000.00
40	22	Сейф 2003/1ш	1/1/2003	10	400,980.00	1	400,980.00
<b>Дүн</b>						<b>70</b>	<b>16,661,172.00</b>
<b>БУСАД ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>							
41	1	Тоос сорогч	2/3/2012	10	237,405.00	5	1,187,025.00
42	2	оюуны өмч улсын бүртгэлийн лавлагаа (программ хангамж)	12/21/2012	4	7,550,000.00	1	7,550,000.00
<b>Дүн</b>						<b>6</b>	<b>8,737,025.00</b>
<b>Нийт дүн</b>						<b>149</b>	<b>106,324,902.84</b>